ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2025/098/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn<br>Ариун төгс оршихуй аудит ХХК-ийн Ахлах аудитор: Г.Баялаг<br>Утас: 89023656 Цахим хаяг: ariuntugsorshihuiaudit@gmail.com<br>Аудитор: Б.Цэцэгмаа<br>Утас: 99484059 Цахим хаяг:Tsetsegmaa@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.02.24 № 99

танай ______________ -ны № ______________ -т

ЦОГТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.БЯМБАДОРЖ ТАНАА

**Сөрөг дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн Цогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

**Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4,16.5.5, 25 дугаар зүйлийн 25.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2, дугаар зүйлийн 15.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.1. 16.2, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Монгол Улс Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралт "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.8,Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх,

8225020251

бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Сургуулийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 16-ны Б/49 дугаартай тушаалаар хэмнэгдсэн төсвөөс сургуулийн удирдлага, багш, ажилтан нарт хоолны хөнгөлөлт 34,161.0 мянган төгрөгийг олгосон
- Батлагдсан орон тооноос 1 орон тоо илүү ажиллуулж, 560.0 мянган төгрөгийн цалинг төсвөөс олгосон,
- Ахмадын сан гэсэн утгаар 2,500.0 мянган төгрөгийг хамааралгүй бүхий этгээдийн дананд шилжүүлсэн,
- Санхүүгийн мэргэшүүлэх тэргүүн академид нягтлан бодогчийн сургалтын төлбөр 1,400.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн,
- Харилцан хамаарал бүхий этгээдэд 19,164.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын А/80 дугаар тушаалын дагуу математик, англи хэлний цахим сургалтын хөтөлбөр хэрэгжиж гэрээний дагуу патентын эрхийн төлбөр болох1,153.1 мянган төгрөгийг шилжүүлж шууд зардлаар тайлагнасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын А/80 дугаар тушаалын дагуу математик, англи хэлний цахим сургалтын хөтөлбөр хэрэгжиж гэрээний дагуу патентын эрхийн төлбөр болох 19,114.5 мянган төгрөгийг шилжүүлж шууд зардлаар тайлагнасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 11 зорилт 41 арга хэмжээний хэрэгжилт 82.5 хувьтай үнэлэгдсэн байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **282,973,548.51** | **367,365,139.66** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **132,059,148.12** | **193,904,032.76** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **132,059,148.12** | **193,904,032.76** |
| **31210** | **Төгрөг** | **132,059,148.12** | **193,904,032.76** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 132,059,148.12 | 193,904,032.76 |
| **33** | **АВЛАГА** | **598,364.40** | **3,761,900.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 598,364.40 | 3,761,900.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **150,316,035.99** | **169,699,206.90** |
| **35100** | **Түүхий эд материал** | **93,542,997.04** | **94,064,597.04** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 92,954,997.04 | 93,069,397.04 |
| 35130 | Эм боох материал | 588,000.00 | 995,200.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **37,860,075.00** | **53,590,410.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,275,800.00 | 1,855,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,553,700.00 | 650,100.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4,000,000.00 | 5,200,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 5,107,000.00 | 11,680,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 19,923,575.00 | 34,205,010.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | 18,912,963.95 | 22,044,199.86 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **857,700,169.64** | **829,481,263.05** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **857,700,169.64** | **829,481,263.05** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **832,369,669.64** | **804,150,763.05** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 891,680,866.59 | 891,680,866.59 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (334,775,187.48) | (392,266,032.15) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 0.00 | 31,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | (21,802,334.52) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 334,744,757.10 | 371,270,426.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (164,222,191.78) | (165,431,433.77) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 158,070,173.70 | 163,880,948.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (109,515,244.85) | (119,958,658.64) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 84,332,160.28 | 82,272,160.28 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (32,831,158.84) | (39,995,180.14) |
| 39217 | Ном | 1,885,494.92 | 0.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **25,330,500.00** | **25,330,500.00** |
| 39301 | Програм хангамж | 2,615,298.00 | 2,615,298.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,615,298.00) | (2,615,298.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,330,500.00 | 25,330,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,140,673,718.15** | **1,196,846,402.71** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,521,596.00** | **46,389,862.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **3,521,596.00** | **46,389,862.00** |
| **41300** | **Өглөг** | **3,521,596.00** | **46,389,862.00** |
| **41360** | **Бусад өглөг** | **3,521,596.00** | **46,389,862.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 3,029,380.00 | 45,970,454.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 492,216.00 | 419,408.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,137,152,122.15** | **1,150,456,540.71** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,137,152,122.15** | **1,150,456,540.71** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,181,487,146.10 | 1,181,487,146.10 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 1,181,487,146.10 | 1,181,487,146.10 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **(355,966,874.78)** | **(342,662,456.22)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (326,505,706.56) | (353,919,630.33) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (29,461,168.22) | 11,257,174.11 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 311,631,850.83 | 311,631,850.83 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,140,673,718.15** | **1,196,846,402.71** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,706,132,372.00** | **2,251,361,825.27** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **23,776,305.75** | **48,278,125.10** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **23,776,305.75** | **48,278,125.10** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **2,275,200.00** | **0.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,240,200.00 | 0.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,000.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 18,770,800.00 | 41,217,135.48 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 2,730,305.75 | 7,060,989.62 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,682,356,066.25** | **2,203,083,700.17** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,426,520,700.00** | **1,952,333,600.17** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,426,520,700.00 | 1,952,333,600.17 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **0.00** | **2,011,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 2,011,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **255,835,366.25** | **248,739,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 255,835,366.25 | 248,739,100.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,735,593,540.22** | **2,238,219,156.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,735,593,540.22** | **2,238,219,156.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,665,223,684.22** | **2,196,136,656.24** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,016,874,603.25** | **1,478,307,800.65** |
| 210101 | Үндсэн цалин | 716,446,060.45 | 932,734,190.72 |
| 210102 | Нэмэгдэл | 247,892,921.09 | 469,345,738.23 |
| 210104 | Урамшуулал | 52,535,621.71 | 76,227,871.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **126,513,078.12** | **181,724,605.86** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 86,222,049.12 | 123,706,832.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,144,000.00 | 14,473,277.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,113,659.00 | 7,337,968.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,024,340.00 | 7,087,006.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,009,030.00 | 29,119,522.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **257,047,366.25** | **249,355,225.62** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,605,702.25 | 9,623,206.62 |
| 210302 | Түлш, халаалт | 240,841,664.00 | 233,832,019.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,600,000.00 | 5,900,000.00 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **0.00** | **6,185,853.71** |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 6,185,853.71 |
| **2105** | **Нормативт зардал** | **75,173,025.00** | **87,380,560.00** |
| 210502 | Хоол, хүнс | 75,173,025.00 | 87,380,560.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,620,500.00** | **16,467,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 10,620,500.00 | 16,467,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,399,600.00** | **16,772,029.85** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,240,200.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,159,400.00 | 16,772,029.85 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **169,595,511.60** | **159,942,980.55** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,776,845.00 | 32,952,020.38 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,097,000.00 | 7,402,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 129,721,666.60 | 119,588,460.17 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **70,369,856.00** | **42,082,500.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **70,369,856.00** | **42,082,500.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 51,639,525.00 | 42,082,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 18,730,331.00 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(29,461,168.22)** | **13,142,669.03** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **0.00** | **1,885,494.92** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 0.00 | 1,885,494.92 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(29,461,168.22)** | **11,257,174.11** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,684,631,266.25** | **2,203,083,700.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,275,200.00** | **2,011,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **2,275,200.00** | **2,011,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **2,275,200.00** | **2,011,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,240,200.00 | 0.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,000.00 | 2,011,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,682,356,066.25** | **2,201,072,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,426,520,700.00** | **1,952,333,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,426,520,700.00 | 1,952,333,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **255,835,366.25** | **248,739,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 255,835,366.25 | 248,739,100.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,597,327,967.02** | **2,102,762,915.36** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,597,327,967.02** | **2,102,762,915.36** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,526,958,111.02** | **2,071,361,339.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,013,951,371.65** | **1,476,929,564.65** |
| 210101 | Үндсэн цалин | 713,522,828.85 | 931,355,954.72 |
| 210102 | Нэмэгдэл | 247,892,921.09 | 469,345,738.23 |
| 210104 | Урамшуулал | 52,535,621.71 | 76,227,871.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **126,513,078.12** | **181,724,605.86** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 86,222,049.12 | 123,706,832.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,144,000.00 | 14,473,277.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,113,659.00 | 7,249,737.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,024,340.00 | 7,175,237.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,009,030.00 | 29,119,522.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **246,845,366.25** | **226,841,599.62** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,605,702.25 | 9,623,206.62 |
| 210302 | Түлш, халаалт | 230,639,664.00 | 211,318,393.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,600,000.00 | 5,900,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **79,697,850.00** | **112,342,920.00** |
| 210502 | Хоол, хүнс | 79,697,850.00 | 112,342,920.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,990,000.00** | **21,547,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 8,990,000.00 | 21,547,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,399,600.00** | **16,772,029.85** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,240,200.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,159,400.00 | 16,772,029.85 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **41,560,845.00** | **35,203,120.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,754,845.00 | 25,835,720.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,806,000.00 | 9,367,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **70,369,856.00** | **31,401,575.38** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **70,369,856.00** | **31,401,575.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 51,639,525.00 | 31,401,575.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 18,730,331.00 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **87,303,299.23** | **100,320,784.64** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **37,958,000.00** | **38,475,900.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **37,958,000.00** | **38,475,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **37,958,000.00** | **38,475,900.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 37,958,000.00 | 38,475,900.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(37,958,000.00)** | **(38,475,900.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **49,345,299.23** | **61,844,884.64** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 82,713,848.89 | 132,059,148.12 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 132,059,148.12 | 193,904,032.76 |
| 100 | Тохируулгын орлого, зарлагын зөрүү | 0.00 | 0.00 |



Төрийн аудитын газар

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,181,487,146.10** | **311,631,850.83** | **(326,505,706.56)** | **1,166,613,290.37** |
| **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,181,487,146.10** | **311,631,850.83** | **(326,505,706.56)** | **1,166,613,290.37** |
| **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **(29,461,168.22)** | **(29,461,168.22)** |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,181,487,146.10** | **311,631,850.83** | **(355,966,874.78)** | **1,137,152,122.15** |
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,181,487,146.10** | **311,631,850.83** | **(355,966,874.78)** | **1,137,152,122.15** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | (875,986.98) | (875,986.98) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,181,487,146.10** | **311,631,850.83** | **(356,842,861.76)** | **1,136,276,135.17** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 2,923,231.43 | 2,923,231.43 |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 11,257,174.11 | 11,257,174.11 |
| **2024 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл** | **1,181,487,146.10** | **311,631,850.83** | **(342,662,456.22)** | **1,150,456,540.71** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,086,779,000.00** | **1,892,499,715.36** | **194,279,284.64** | **90.69** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,086,779,000.00** | **1,892,499,715.36** | **194,279,284.64** | **90.69** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,039,822,700.00** | **1,861,098,140.36** | **178,724,559.64** | **91.24** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,605,508,900.00** | **1,476,929,564.65** | **128,579,335.35** | **91.99** |
| 210101 | Үндсэн цалин | 1,036,658,900.00 | 931,355,954.72 | 105,302,945.28 | 89.84 |
| 210102 | Нэмэгдэл | 513,491,900.00 | 469,345,738.23 | 44,146,161.77 | 91.40 |
| 210104 | Урамшуулал | 55,358,100.00 | 76,227,871.70 | (20,869,771.70) | 137.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **200,688,700.00** | **181,724,605.86** | **18,964,094.14** | **90.55** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 136,468,200.00 | 123,706,832.00 | 12,761,368.00 | 90.65 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,055,100.00 | 14,473,277.00 | 1,581,823.00 | 90.15 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,027,600.00 | 7,249,737.00 | 777,863.00 | 90.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,027,600.00 | 7,175,237.00 | 852,363.00 | 89.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,110,200.00 | 29,119,522.86 | 2,990,677.14 | 90.69 |
| **2105** | **Нормативт зардал** | **113,161,000.00** | **112,342,920.00** | **818,080.00** | **99.28** |
| 210502 | Хоол, хүнс | 113,161,000.00 | 112,342,920.00 | 818,080.00 | 99.28 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **27,362,000.00** | **16,772,029.85** | **10,589,970.15** | **61.30** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 312,800.00 | 0.00 | 312,800.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 27,049,200.00 | 16,772,029.85 | 10,277,170.15 | 62.01 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **93,102,100.00** | **73,329,020.00** | **19,773,080.00** | **78.76** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 81,118,400.00 | 61,425,720.00 | 19,692,680.00 | 75.72 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,983,700.00 | 11,903,300.00 | 80,400.00 | 99.33 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **46,956,300.00** | **31,401,575.00** | **15,554,725.00** | **66.87** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **46,956,300.00** | **31,401,575.00** | **15,554,725.00** | **66.87** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 46,956,300.00 | 31,401,575.00 | 15,554,725.00 | 66.87 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,086,779,000.00** | **1,954,344,600.00** | **132,434,400.00** | **93.65** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,952,333,600.00** | **1,952,333,600.00** | **0.00** | **100.00** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,952,333,600.00 | 1,952,333,600.00 | 0.00 | 100.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **134,445,400.00** | **2,011,000.00** | **132,434,400.00** | **1.50** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 312,800.00 | 0.00 | 312,800.00 | 0.00 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,011,000.00 | 2,011,000.00 | 0.00 | 100.00 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 132,121,600.00 | 0.00 | 132,121,600.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төсвийн тохируулга |
|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **248,739,100.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **248,739,100.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **248,739,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 248,739,100.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **248,389,100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **248,389,100.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **248,389,099.62** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **226,841,599.62** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,623,206.62 |
| 210302 | Түлш, халаалт | 211,318,393.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,900,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **21,547,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 21,547,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **0.38** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.38 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **350,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **350,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **350,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **350,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 350,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(350,000.00)** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй болно.

Залруулагдаагүй нийт 58,520.5 мянган төгрөгийн зөрчил нь түвшнээс тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их, харилцан хамааралтай этгээдээс худалдан авалт хийсэн тул “Сөрөг” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 58,520.5 мянган төгрөгийн 6 зөрчил[1] илэрснээс, 1,960.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 22,399.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 34,161.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

1. Санхүүгийн мэргэшүүлэх тэргүүн академид нягтлан бодогчийн сургалтын төлбөрт 1,400.0 мянган төгрөгийг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; 16 дугаар зүйлийн 16.5.5.-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөгдөөгүй бусад” гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Батлагдсан орон тоонд байхгүй, төлөвлөлтөд тусгаагүй ажил хавсарсны нэмэгдэлд 560.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;”, 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Албан шаардлага

1. Тайлант оны 10 дугаар сарын 01-ний өдөр Б.Бямбадоржийн Төрийн банкны 241329234435 дугаартай данс руу 2,500.0 мянган төгрөгийг ахмадын сан гэсэн утгаар шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно ” гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсөв захирагч нь өөрөө болон өөрт хамаарал бүхий этгээдтэй ашиг сонирхлын нөхцөл байдал бий болгосон зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

---

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Санхүүгийн ажилтанд санхүүгийн тайланг хугацаанд нь гаргаж ажилласан үндэслэлээр хууль тогтоомжид заасан хэмжээнээс 735.5 мянган төгрөгөөр илүү шагнал, урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3-т "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасантай нийцэхгүй байна

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвийг хэмнэлттэй үр ашигтай байхаар төлөвлөн хуульд зааснаас бусад зардлыг гаргахгүй байх зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Харилцан хамаарал бүхий этгээдийн дансанд 19,164.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно ” гэж заасантай нийцэхгүй байна

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Хамаарал бүхий этгээдтэй гүйлгээ хийж буй явдлыг таслан зогсоож, худалдан авалтад дотоод хяналтыг хэрэгжүүлэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.3.1 *Зардалтай холбоотой асуудал*

<u>Илрүүлэлт:</u> Сургуулийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 16-ны Б/49 дугаартай тушаалаар хэмнэгдсэн төсвөөс сургуулийн удирдлага, багш, ажилтан нарт хоолны хөнгөлөлтөд 1 өдрийн 3000 төгрөгөөр тооцон олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 16.5.6.дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх; гэж заасантай тус тус нийцээгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u> Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөх, байгууллагын дотоод хяналтын баг томилон хяналт хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл* *(мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Цогт сумын Ерөнхий боловсролын сургууль | Цогт сумын ЗДТГ-аас Засаг даргын мөрийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд олгосон эх үүсвэрийг УТ-ийн санхүүжилтийн орлогоор бүртгэсэн | 1 | 1,836.0 | - | - | 1 | 1,836.0 | 1 | 1,836.0 | - | - | - | - |
| | Цахим тендерийн баримт бичгийн орлогыг УТ-ийн санхүүжилтийн орлогоор бүртгэсэн | 1 | 175.0 | - | - | 1 | 175.0 | 1 | 175.0 | - | - | - | - |
| | Алтан тулга молл ХХК-д 2024 оны 12 дугаар сарын 27-нд бичиг хэргийн материал, принтер худалдан авахаар төлбөрийг шилжүүлсэн санхүүгийн баримтад бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн зарлагын баримт 2025 оны 01 дүгээр сарын 14-ний огноо | 1 | 3,761.9 | - | - | 1 | 3,761.9 | 1 | 3,761.9 | - | - | - | - |
| | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд зарцуулсан зардлыг 210502 хоол, хүнсний зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн | 1 | 42,082.5 | -- | - | 1 | 42,082.5 | 1 | 42,082.5 | - | - | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ҮЭ-ийн 738.8, хувь хүнээс илүү суутгасан 419.4, хамтын сангийн -20.0, урьдчилгаа илүү суутгасан-200.0 | 1 | 1,378.2 | - | - | 1 | 1,378.2 | 1 | 1,378.2 | - | - | - | - |
| | Есөн булгийн төрийн санд шилжүүлсэн өмнөх оны өглөгийГ 2024 оны 02 дугаар сарын 22-нд зардлаар бүртгэсэн | 1 | 1,992.4 | - | - | 1 | 1,992.4 | 1 | 1,992.4 | - | - | - | - |
| | Төлбөрийг нь урьдчилан шилжүүлсэн бараа материалыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн | 1 | 3,761.9 | - | - | 1 | 3,761.9 | 1 | 3,761.9 | - | - | - | - |
| | Дулаан эрчим хүчээр хангах байгууллагатай тооцоо нийлээгүй гэрээнд заасан төлбөрийг бүрэн төлөөгүй өглөг дутуу тусгасан | 1 | 30,573.6 | - | - | 1 | 30,573.6 | 1 | 30,573.6 | - | - | - | - |
| | Тайлант үеийн үр дүн зөрүүтэй илэрхийлсэн | 1 | 31,951.9 | - | - | 1 | 31,951.9 | 1 | 31,951.9 | - | - | - | - |
| | | | **9** | **117,513.4** | | **9** | **117,513.4** | | **9** | **117,513.4** | | | |

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | 1 | | | | | 1 | |
| | **НИЙТ** | | **1** | | | | | **1** | |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР